

Музейн эд өлгийн зүйлийг хадгалж хамгаалахад тавиур (tray) чухал үүрэгтэй. Оксфордын толь бичигт “Тавиур гэдэг нь жижиг хэмжээтэй эд зүйлийг зөөх болон үзүүлэгт байрлуулахад хэрэглэдэг намхан хашлагатай тавиур юм” гэжээ. Мөн ийм тавиурыг сан хөмрөгийн шүүгээнд байрлуулж, дотор нь өлгийн зүйлийг хөөсөнцөрт суулган хөдөлгөөнгүй хадгалдаг байна.

Эд өлгийн зүйлийг зөөх болон байрлуулахад хэрэглэх тавиур хийх заавар

Дараах эд өлгийн зүйлд тавиур шаардагдахгүй. Үүнд:

- Тогтвортой, суурь сайтай
- Бат бөх
- Гэмтэхээргүй гадаргуутай
- Металл бус
- Өлгүүр тогтоогуур зэрэг саланги хэсэг байхгүй эд өлгийн зүйл
- Гараар барихад гэмтэхээргүй эд өлгийн зүйл
- Шавар ваар зэрэг нэг цул биет

Дараах эд өлгийн зүйлд тавиур хийх хэрэгтэй. Үүнд:

- Хуйлаатай, бөөрөнхий, оройн хэсэг нь данхар, цав гарсан зэрэг тогтворгүй, бат бөх бус
- Металл – ажилтан бээлийгүй нөхцөлд хайрцагтай нь барьж болохоор
- Эд өлгийн зүйлийн нэг хэсэг нь салж унахаар хэрвэг болсон
- Гадаргуу нь эмзэг, будаг ховхорч байгаа, хэврэгшсэн
- Өлгүүртэй буюу хэд хэдэн хэсгээс бүтсэн
- Нэг цул биет бус
- Тавиургүй зөөх, харьцах боломжгүй
- Алга болж болзошгүй жижиг эд өлгийн зүйл

Тавиур хийхдээ анхаарах зүйлс:

- Эд өлгийн зүйлийн хэмжээнд таарсан, сан хөмрөгийн зориулалтын тавиур олохыг хичээх
- Зориулалтын тавиур байхгүй бол дан болон давхар картон цаасаар тавиур суурь хийх
- Эд өлгийн зүйлийнхээ хэмжээнд тохируулах
- Тавиурын өндөр нь эд өлгийн зүйлийн хэврэг хэсгүүдийг хамгаалахуйц байхын зэрэгцээ аль болох намхан байх
- Тавиурын бүх өнцгүүдийг тэгш өнцөгт байхаар цэвэрхэн тайрч, цавууг харагдахааргүй наана.
- Тавиур нь ашиглахад хир эвтэйхэн болохыг туршиж үзэх
- Эд өлгийн зүйлийг хөдөлгөөнгүйгээр тавиурт байрлуулахын тулд ёроолд нь эд өлгийн зүйлийн дүрсийг харандаагаар зурна.
- Цаасаа огтлох хэмжээ авахдаа тавиурын дөрвөн талын өндрийг нугалах зай үлдээх
- Хэмжээгээ харандаагаар зурах
- Өнцгүүдийг сайн үдээсээр үдэх (нугалахдаа тэгш нугалахын тулд тусгай багаж ашиглах – bone folder)

- Давхар хийх тохиолдолд цэвэрхэн нугалахын тулд гадна талд нь нугалах хэрэг гарч мэднэ.
- Хутгаар материалаа зүсэхдээ нэг хоёр удаа чанга дарж зүссэнээс хэд хэдэн удаа хөнгөн зүсэх нь дээр байдаг. Чанга дарахад тэгш болохгүй.
- Өнцгүүдээ их халуун цавуугаар наах ба сайн наалдтал нь дарах
- Мөн хавчаараар хавчих
- Өнцөгний илүү гарсныг нь гурвалжлан нугална.
- Тавиурын ёроолд зөөлөвч тавих ба зөөлөвчийн нэг талыг эд өлгийн зүйлийн дүрсний дагуу ухаж авна. (бөх бат болгохын тулд ёроолд нь blueboard гэдэг материалыг давхарлаж дэвсэх, Blueboard- гэдэг нэг нимгэн хавтан, 2 ба 3 давхар болгож болно. Гадна талд нь нимгэн цаас бий, түүнд нь хөөсөнцөр болон бусад материалыг нааж, үзмэрээ тусгаарлана?
- Тавиурын хоёр талд эд өлгийн зүйлийн каталогийн дугаарыг (төрөлжсөн бүртгэлийн дугаар буюу төрөлжсөн бүртгэлийн дугаар байхгүй бол хувийн дугаар) том үсгээр харандаагаар гаргацтай бичнэ.

Ашигласан материал:

1. АНУ-ын Смитсоны Институтын Материалын судалгаа ба боловсролын ажлын төвийн гарын авлага. “Tray rehousing guidelines”
2. The Oxford Popular English Dictionary. Parragon book service Ltd 1998. p.886.

Орчуулсан: Д.Бумаа Ph,D, Г.Гантуяа